

“Тэр амьд! Түүний нэр алдаршиг!”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г.Скотт

Есүс Христийн цагаатгалын талаарх бидний ойлголт болон итгэл нь амжилттай амьдрахад шаардагдах хүч тэнхээ, боломжийг өгдөг.

Өнөө өглөө бол Улаан өндөгний баярын өглөө. Энэхүү ариун өдөр Христийн бүх шашинтнууд үхлийг ялсан Есүс Христийн ялалтыг тэмдэглэдэг. Түүний Амилалт тэр үеийг хүртэл давагдашгүй хэмээн ойлгогдож байсан үхлийн гинжийг тас татсан юм. Тэр дэлхийд төрсөн Тэнгэрлэг Эцэгийн хүүхэд бүрт үхлээс босч дахин амьдрах боломж бүхий замыг нээж өгсөн.

Бидний Тэнгэрлэг Эцэг тэрхүү ариун өдөр туйлын дуулгавартай, төгс зохистой Хүү нь үхлийн гинжийг тас цохисонд хэчнээн их баяртай байсан бол. Бидний Эцэгийн аз жаргалын мөнхийн төлөвлөгөө Түүний төгс дуулгавартай Хүүгийн мөнхийн, хязгааргүй Цагаатгалаар дамжин биеллээ олоогүй бол уг төлөвлөгөөний зорилго юу байхсан билээ? Хэрэв үхэл бидний оршихуйн төгсгөл байгаад хэн ч амилуулагдахгүй юм бол, сүнс болон бүрэлдсэн оюун ухаанууд биеийг авахын тулд ирэх дэлхийг бүтээсний мөнхийн зорилго юу байхсан билээ? Тэр өглөө тохиосон тэрхүү алдар суут агшны ач холбогдлыг ойлгодог бүх хүнд энэ нь хамгаас агуу юм.

Улаан өндөгний баяр бол гүн бишрэлтэй Христэд итгэгч бүрийн зүрх сэтгэл бидний хайрт Аврагчид даруухан талархлаар ханддаг ариун өдөр юм. Энэ нь Түүнийг хайрладаг,хайраа Түүний зарлигуудыг дуулгавартай сахиснаар харуулдаг бүх хүнд амар амгалан, баяр баясгаланг авчирдаг цаг үе билээ. Улаан өндөгний баяраар бид Есүсийн амьдрал, Түүний Цагаатгал, Амилалт, хайрыг эргэцүүлэн боддог. Тэрээр “жигүүртээ эдгэрлийг авчран” (Малахи 4:2; 3 Нифай 25:2) үхэгсдээс амилан босч ирсэн юм. Гэтэлгэгчийн өгч чадах тэрхүү эдгээлт бид бүгдэд хэчнээн их хэрэгтэй билээ! Агуу Багш, Есүс Христийн сургаалуудад агуулагдсан зарчмуудаас ирэх итгэл найдварын мэдээг би та бүхэнд хүргэж байна.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд Түүний Цагаатгалаас ирэх эдгээлтийн цар хүрээг илүү бүрэн дүүрэн ойлгож чадна. Учир нь Түүний сургаал бидэнд бүрнээрээ байдаг. Тэсэхүйеэ бэрх зовлон шаналал амсаж, сайн дураараа золиослол хийсэн нь бидэнд зөвхөн энэ амьдралд төдийгүй бүх үүрд мөнхийн туршид нөлөөлснийг бид ойлгодог.

Улаан өндөгний баярын үеэр Амилалт болон Цагаатгалаар дамжуулан төлсөн төлөөс, өгсөн бэлгийг нь санахдаа судрууд бидэнд тэрхүү ариун үйл явдлуудын тухай юу заадгийг тунгаан бодогтун. Эдгээр үйл явдлуудын бодит үнэний тухай хувийн гэрчлэл чинь бэхжих болно. Эдгээр нь та нарын цээжилдэг зарчмуудаас илүү чухал байх ёстой. Цагаатгалын эдгээр зарчмуудыг бид бодгалийнхаа нэг хэсэг болгож, дэлхийг хамрах нь ихэсч буй гэм нүглийн жигшүүрт давалгаанаас хамгаалах далан болгон ашиглах ёстой.

Бошиглогч Лихай, “Иймийн тул, Ариун Мессиа, түүнд мөн түүгээр гэтэлгэл ирнэ; учир нь тэрээр ач ивээл хийгээд үнэнээр дүүрэн буюу. Болгоогтун, харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэй хэний ч төлөө хуулийн шаардлагуудыг хангаж, тэрээр нүглийн золиослол болгон өөрийгөө өргөх ажгуу, мөн хуулийн бүх шаардлагууд өөр хэний ч төлөө хангагдаж чадахгүй” (2 Нифай 2:6-7) хэмээх агуу үнэнийг тунхагласан. Энэхүү сударт бардамнагчид, ихэрхэгчдийн хувьд цагаатгал хэзээ ч байгаагүй хэмээн заадаг.

Есүс Христ амьд. Тэр бол бидний Аврагч, Гэтэлгэгч. Тэр бол сүр жавхлан төгс, амилсан хүмүүн бие мөн. Үгээр илэрхийлэхийн аргагүй агуу, гайхан биширмээр хайраа илэрхийлэх чадвар түүнд байдаг. Үхлийн хүлээсийг тайлахын тулд Тэрээр амиа өргөсөн юм. Түүний Цагаатгал Тэнгэр дэх Эцэгийнхээ аз жаргалын төлөвлөгөөг бүрэн дүүрэн үр ашигтай болгосон билээ.

Түүний сайн мэдээнд бид хэр зэрэг дуулгавартай байсны дагуу Есүс шударга ёс, нигүүлсэл хоёрын тэнцвэртэй байдлыг бидэнд хангаж өгдөг. Тэр бол бүх хүн төрөлхтний гэрэл юм. Тэр бол бүх үнэний ундрага. Тэрээр бүх амлалтаа биелүүлдэг. Түүний зарлигуудыг дуулгавартай сахидаг бүх хүн төсөөлөхийн аргагүй агуу адислалуудыг авах болно.

Цагаатгалгүйгээр Тэнгэр дэх Эцэгийн аз жаргалын төлөвлөгөө үр нөлөөгөө бүрэн өгч чадахгүй байсан. Цагаатгал нь амьдралд гарсан алдаа мэдгийн үр дагавруудыг даван туулах бүх боломжийг олгодог. Бид хуулийг дуулгавартай дагаснаар адислал авдаг. Бид хуулийг зөрчсөн үед тэрхүү зөрчигдсөн хуулийн төлөө шударга ёсны шаардлагыг хангахын тулд өнгөрсөн үеийн дуулгавартай байдлаа ашиглаж чадахгүй. Аврагчийн Цагаатгал аливаа дуулгаваргүй байдлаа наманчлах боломжийг бидэнд олгодог. Ингэснээрээ шударга ёсны шаардлагаас үүдэлтэй шийтгэлээс бид зайлсхийж чадна.

Израилын Ариун Нэгэн, Энхийн Жонон, бидний Гэтэлгэгчийн Цагаатгалын тухай илүү ихийг ойлгох гэж хичээхийн хэрээр миний Түүнд өгөх хүндэтгэл, талархал байнга өргөжин гүнзгийрдэг билээ. Цагаатгалаараа дамжуулан Тэнгэрлэг Эцэгийн

хүүхдүүдийн төлөө Есүс Христийн хийсэн бүх зүйлсийн ач холбогдлыг мөнх бус хүмүүний оюун ухаан бүрэн дүүрэн ухаарч, хүмүүний хэл зохих ёсоор дүрсэлж чадахгүйг би ойлгосон. Гэвч бид үүний талаар чадах чинээгээрээ сурч мэдэх нь чухал юм. Цагаатгал бол Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөний нэн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Цагаатгалгүйгээр уг төлөвлөгөө хэрэгжих боломжгүй байлаа. Цагаатгалын тухай та бүхний ойлголт нь үүний үр дүнд амьдралд тань бий болдог хэрсүү ухаан, мөнх бус амьдралд олж авсан мэдлэг, туршлага, ур чадвараа хамгийн үр өгөөжтэйгээр ашиглах боломжийг танд олгох болно.

Цагаатгал Эцэг, Хүү хоёроос аль алинаас нь юу шаардсаныг төсөөлөн бодохыг хичээх нь сургамжтай юм гэдэгт би итгэдэг. Аврагч гурван сорилттой тулгарсан юм:

Нэгдүгээрт, асар их хариуцлагатай байдал. Хэрэв энэ хариуцлагыг төгс биелүүлэхгүй юм бол Эцэгийнх нь хүүхдүүдээс нэг нь ч Түүнд эргэж очиж чадахгүй байлаа. Зөрчигдсөн хуулийн төлөө наманчлах өөр арга зам байгаагүй, цэвэр ариун биш ямар ч зүйл Бурханы дэргэд оршиж чадахгүй учраас тэд Түүний оршихуйгаас үүрд тусгаарлагдаж шийтгэгдэх байлаа. Эцэгийнх нь төлөвлөгөө бүтэлгүйтэж, сүнсэн хүүхэд бүр нь Сатаны мөнхийн хяналт, тарчлал дор орших байв.

Хоёрдугаарт, Тэрээр хүн төрөлхтний бүх гэм нүглийн үр дагавруудыг, бүр хамгийн адгийн, жигшмээр муухай нүглийг төгс цэвэр оюун ухаан, зүрх сэтгэлдээ мэдрэх ёстой байсан.

Гуравдугаарт, Тэрээр Сатаны үй олон дагалдагчдын түрэмгий дайралтыг бие махбод, сэтгэл санааны хязгаарлагдмал чадвараараа хүлцэн тэвчих шаардлагатай байлаа. Аврагч хүч чадлаа дээд зэргээр шавхан дайчилж, Түүнд тусламж дэмжлэг хамгийн их хэрэгтэй байсан тэр үед бидний бүрэн үл мэдэх шалтгаанаар Эцэг нь Хүүдээ зөвхөн өөрийнхөө хүч чадлаар тэсэж гарах асар хүнд хариуцлагыг үүрүүлсэн юм.

Тэнгэр дэх бидний Эцэгийн хувьд хамгийн сэтгэл эмзэглэм хором бол Аврагч загалмай дээрээс, “Бурхан минь, Бурхан минь, юунд Та намайг орхив?” (Матай 27:46; Марк 15:34) гэж хашгирсан тэр агшин гэж би боддог. Тэнгэр дэх Эцэг Хүүгээ загалмай дээр орхисон гэдэгт би итгэдэггүй. Тийнхүү хашгирсан нь Эцэгээсээ үргэлж авдаг байсан дэмжлэг туслалцаа яг тэр агшинд Хүүд үгүйлэгдсэн гэдэгт би итгэдэг. Аврагч төгс Цагаатгалыг гадны тусламж дэмжлэггүйгээр ганцаараа гүйцэлдүүлэх хэрэгтэй байсныг Түүний Эцэг ойлгож

байсан. Эцэг нь Хүүгээ орхиогүй юм. Тэрээр Цагаатгалын мөнхийн үр жимсийг бий болгох боломжийг төгс төгөлдөр Хүүдээ олгосон билээ.

Мөнх бус байдалд бидний хэн нь ч Цагаатгалын үнэ цэнэтэй үр нөлөөг бүрэн дүүрэн үнэлж цэгнэж чадахгүй.

Есүс Христийн Цагаатгал бидний амьдралаа төвхнүүлэх ганхашгүй үндэс суурь байхын тулд Цагаатгалын ач холбогдлыг ойлгох ойлголтоо гүнзгийрүүлж бататгах зайлшгүй хэрэгцээ бид бүгдэд байдаг. Дэлхий дур хүслээ эн тэргүүнд тавьж, хүндэтгэл, ариун журам, цэвэр ариун зан чанарын суурь жишгүүдийг улам бүр умартсаар байгаа үед Есүс Христийн Цагаатгалыг ойлгож, үүнд итгэх нь амьдралаа өнгөтэй өөдтэй, амжилт бүтээлтэй авч явахад хэрэгтэй хүч чадал, чадвараар биднийг хангах болно. Энэ нь бас хүнд сорилт бэрхшээлийн цагт итгэл найдварыг, үймээн самууны үед амар амгаланг авчрах болно.

Бидний Аврагч, Гэтэлгэгч байх бурханлагаар томилогдсон дуудлагаа Есүс Христ төгс биелүүлсний мөнхийн, хязгааргүй, юутай ч зүйрлэшгүй үр нөлөөг илүү сайн ойлгож, эрхэмлэн дээдлэхийн тулд хувийн судалгааны төлөвлөгөө гаргаж ажиллахыг би та бүхэнд уриалж байна. Судруудын талаар ул суурьтай тунгаан бодож, чин сэтгэлээсээ эрж хайсан залбирлыг хийх нь Түүний үнэлж баршгүй Цагаатгалын тухай бидний ойлголт, талархлыг улам хүчтэй болгоно. Есүс Христ болон Түүний цагаатгалын талаар сурч болох өөр нэгэн хүчирхэг арга бол Ариун сүмд тогтмол очих явдал юм.

Гэрийнхээ ариун тайван орчинд үнэн зарчмуудыг заах шийдвэр төгс байдлаа бүгдээрээ шинэчилцгээе. Ингэснээрээ, бидэнд итгэл хүлээлгэн даатгасан Бурханы сүнсэн хүүхдүүдийг аз жаргалд хүргэх агуу боломжуудаар бид хангаж чадна. Гэр бүлийг бэхжүүлэхэд Сүмийг зөв хөшүүрэг болгон ашигла. Гэвч эцэг эхчүүд бидний хайр, халамжинд итгэл хүлээлгэн даатгасан Түүний сүнсэн хүүхдүүдийг өсгөн хүмүүжүүлэх үндсэн үүрэг хариуцлагыг үүрэх ёстой бөгөөд энэ үйлсэд Их Эзэнээр удирдуулах онцгой боломж бидэнд байдаг.

Гэр бүлдээ үнэнийг заах нь нэн чухал, тулгуур зарчим мөн. Сүм үүнд чухал үүрэгтэй. Гэвч эцэг эхчүүд хүүхдүүддээ зааж, удирдан чиглүүлэх газар бол тэдний гэр юм. Энэ амьдралд болон үүрд мөнхөд хамгийн чухал дуудлага бол эцэг эхийн дуудлага мөн гэсэн үг үнэхээр үнэн юм. Заримдаа бид хүлээж авсан бусад үүрэг даалгавраасаа чөлөөлөгддөг бол эцэг эхийн үүргээсээ хэзээ ч чөлөөлөгддөггүй.

Та нар судруудыг зөвхөн унших төдийгүй, тунгаан бодож бясалгах юм бол Ариун Сүнсний хүч үнэнийг, бидний амьдарч байгаа тодорхой бус энэ цаг үед аюулгүй, бат бөх суурь болгон та нарын оюун санаа, зүрх сэтгэлд шингээх болно. Эцэг эхчүүд та нар хүүхдүүддээ тулгарч болох сорилт бэрхшээлүүдэд тэднийг бэлтгэ. Хүүхдүүддээ үнэнийг зааж, үнэнээр амьдрахад нь урамшуулан дэмжих юм бол дэлхий хэчнээн донсоллоо ч гэсэн тэд ажрахгүй байх болно.

Улаан өндөгний баяраар Их Эзэн Есүс Христийг гэр бүлийн амьдралынхаа гол утга учир болгоорой. Гаргах шийдвэр бүхэн чинь сүнснийх ч байна уу материаллаг талынх ч байна уу “Их Эзэн Есүс Христ надаар юу хийлгэхийг хүсэхсэн бол?” гэсэн бодол санаагаар удирдагдаж байхад анхаарагтун. Хэрвээ танай гэр бүл Аврагч дээр төвлөрсөн бол гэр орон тань амар амгалангаар дүүрэх болно. Тэгсэн үед хүүхэд, насанд хүрэгчид аль аль нь гэр бүл, гэр оронд тань бялхах амар амгалангийн сүнсээр дүүрэх болно.

Сайн өөрчлөлтөд эргэлт буцалтгүй хүргэх шилдэг арга зам бол Есүс Христийг болон Түүний сургаалуудыг амьдралынхаа хөтөч болгох явдал мөн.

Хэрвээ та Түүний зарлигуудад дуулгаваргүй байж, Түүнд ирэхээр зохисгүй байдалд байгаа бол, Их Эзэн Есүс Христ энэхүү учир шалтгаанар л амиа золиосолсныг ойлгоорой. Тэрбээр Цагаатгалаараа дамжуулан алдааг засч залруулах, буруу сонголтынхоо төлөө наманчлах, Түүний сургаалд харш байдлаар амьдарсны сөрөг үр дагавруудыг даван туулах боломжийг үүрд нээсэн юм.

Аврагч хүн нэг бүрт хайртай бөгөөд дуулгавартай байдлаараа энэ дэлхий дээр биднээс Түүний хүсдэг бүх адислалыг авч, бүх хэрэгцээгээ хангах боломжийг олгох болно. Би Түүнийг хайрладаг, Түүгээр бахархан биширдэг. Эрх мэдэл олгогдсон Түүний үйлчлэгчийн хувьд үүнийг бие сэтгэлийнхээ бүх чадлаар, Тэр амьд гэдгийг гэрчилж байна. Есүс Христийн нэрээр, амен.